

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

(2015 оны жилийн эцэс)

Худалдан авах ажиллагааны газар

2016-02-08

Улаанбаатар хот

Зорилтын дугаар	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт	Яам, агентлагийн үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ	Тайлбар
НЭГ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТой МОНГОЛ ХҮН						
17	Тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулж, захиалагч нь шийдвэрлэдэг өнөөгийн тендерийн тогтолцоог өөрчилж гүйцэтгэгч нь шийдвэрлэдэг болгох	<p>1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, объектыг чанартай гүйцэтгүүлэх зорилгоор Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компанийн дотроос дадлага туршлагатай, нэр хүнд бүхий аж ахуйн нэгжүүдийн чансааг тодорхой шалгуур үзүүлэлтээр олон нийтийн хяналт дор жил бүр тогтоон мэдээлж байна.</p> <p>2. Зураг төсөл, төсөв нь батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгохдоо чансаа нь тогтоогдсон компаниудаас захиалагч өөрөө сонгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.</p> <p>3. Цахим худалдан авах ажиллагааны систем</p>	<p>(Шалгуур үзүүлэлтийг Сангийн яам тодорхойлно. Энэхүү заалт нь манай байгууллагаас хамаарахгүй, хэрэгжүүлэх боломжгүй байх тул хэрэгжилтийн хувийг тооцоогүй)</p> <p>Одоогийн мөрдөж байгаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д энэ асуудал тусгагдаагүй тул хэрэгжихгүй байгаа. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.</p> <p>(Манайхаас шууд хамаарахгүй тул хэрэгжилтийн хувийг тооцоогүй)</p> <p>Монгол Улсад цахим худалдан авах ажиллагааны системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын</p>	-	-	

		<p>(e-Shopping Mall) -ийг ашиглалтад оруулна.</p>	<p>олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар тус улсын Samsung SDS компани 2010-2012 онуудад “Монгол улсад цахим худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх” төслийн I үе шатны ажлыг хэрэгжүүлсний дүнд цахим худалдан авах ажиллагааны систем www.meps.gov.mn -ийг ашиглаж, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлууд үе шаттайгаар хэрэгжив.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт 2012 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр Цахим хэлбэрээр тендер шалгаруулалт зохион байгуулах хууль, эрх зүйн орчин бүрдсэн. Сангийн сайдын 2013 оны 01 сарын 11-ний өдрийн 07 тоот тушаалаар “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам” батлагдсан бөгөөд энэхүү журмаар Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага - ХААГ нь Цахим худалдан авах ажиллагааны системийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны системийн эхний шатыг хэрэглээнд нэвтрүүлэн ашигласнаар төрийн байгууллага хоорондын мэдээллийн солилцоог сайжруулж, мэдээллийн бодит байдлыг тендер шалгаруулалтад ашиглах, цаг хугацааг хэмнэж, үйлчилгээг шуурхай болгон хөнгөвчилсөн эерэг үр дагаврыг бий болгосон. Өнөөгийн байдлаар, Монгол банктай валютын ханшны мэдээлэл, арилжааны банкуудтай цахим тендерт оролцох хураамж, тендерийн баталгааны мэдээллийг цахим хэлбэрээр солилцон ажиллаж байна. Энэ нь тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд тендерийн баталгааг хуурамчаар үйлдэх боломжийг хаасан, сайн үр дагаврыг үзүүлж байгаа. Түүнчлэн, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн системээс тендерт оролцогч аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого, тайлант үеийн ашиг, алдагдал, түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн мэдээлэл авах техникийн боломжийг бүрдүүлснээр тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд санхүүгийн тайлангийн мэдээллээ тендерийн саналд оруулах шаардлагагүй болгон хялбаршуулсан. Татварын ерөнхий газрын мэдээллийн системтэй холбогдож тендерт оролцогчдын татвар төлөлтийн мэдээлэл, борлуулалтын</p>	70%		
--	--	---	--	-----	--	--

орлогын мэдээллийг цахим хэлбэрээр магадлах программ хангамжийн шийдлийг боловсруулж туршсан.

ХААГ-аас 2014-2015 онд 1.5 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Цахим худалдан авах ажиллагааны 2-р үе шат” төслийг хэрэгжүүлж системийг боловсронгуй болгох арга хэмжээ аван худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийн олон системүүдийг нэгтгэж, нэгдсэн сан бүхий нэг систем бүрдүүлэн 2016 онд хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Одоогийн байдлаар “Цахим худалдан авах ажиллагааны системийн 2-р үе шат” төслийн хүрээнд хийгдэж байгаа цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийн шинэчлэлийн ажил 100 хувьтай гүйцэтгэгдээд байгаа бөгөөд шинэ системийг Үндэсний Дата төвд байршуулсан. Энэхүү систем нэвтэрснээр улсын хэмжээний худалдан авах ажиллагаа цахим хэлбэрт шилжиж, мэдээллийн нэгдсэн сан бүрдэнэ. Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүд тендер шалгаруулалтад оролцохын тулд бусад төрийн байгууллагуудаас тодорхойлолт авах явдлыг хялбаршуулан төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог нэмэгдүүлж, мэдээллийн нэг эх үүсвэр бий болгон тендерийн үнэлгээнд харгалзах үзүүлэлтүүдийг системээс үнэлэх боломж бүрдэж байгаа давуу талууд бий болох юм.

Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтын шалгалтыг цахим хэлбэрээр авах ажил энэхүү системээр 2015 оны 03 сараас эхлэн хийгдэж байгаа нь улсын хэмжээнд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн



дэлгэрэнгүй бүртгэл, тендерийн үнэлгээний хороонд томилогдон ажиллаж буй албан хаагч, төрийн бус байгууллагын төлөөллийн


		<p>бүртгэл - мэдээллийг энэхүү сангаас сонгон үүсгэх боломжтой болсон. 2015 оны жилийн эцсийн байдлаар цахим хэлбэрээр 267 удаагийн шалгалт (үүнээс орон нутагт 38 удаа) авсан бөгөөд тэдгээрт 2911 хүн хамрагдснаас 1298 хүн тэнцэж нөөцөд хамрагдсан байна. Уламжлалт (цаасаар) хэлбэрээр авдаг байсан уг шалгалтыг цахим хэлбэрт оруулсан нь технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, шударга, түргэн шуурхай, хэмнэлттэйгээр зохион байгуулахад зохих үр дүнгээ өгч байна.</p> <p>Төрийн байгууллагуудын урсгал зардлыг хэмнэлттэй, үр ашигтай болгох, урсгал зардлаар санхүүжигддэг барааны худалдан авалтыг ил тод болгох зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Худалдан авах ажиллагааны газраас Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-тай хамтран “Цахим дэлгүүр”-ийг ашиглалтад оруулах бэлтгэл хангах, Ерөнхий гэрээ байгуулах замаар хэрэгжих худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Энэ хүрээнд, Худалдан авах ажиллагааны газар (ХААГ), Сангийн яам, ЕСБХБ хамтран “Ерөнхий гэрээ нэвтрүүлсэн сайн туршлага” семинарыг 2015 оны 03 сарын 30-31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус семинарт Австри, Португал, Гүрж улсын худалдан авах ажиллагааны олон улсын зөвлөхүүд оролцож, Монгол Улсын худалдан авах ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал болон Монгол Улсад худалдан авах ажиллагааны Ерөнхий гэрээ нэвтрүүлэх ажлын стратеги, эрх зүйн орчны талаар хэлэлцэж, харилцан туршлага солилцсон. “Ерөнхий гэрээ”-г хэрэгжүүлэх ажлын нэг үе шат болох бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн судалгааг ЕСБХБ-ны дэмжлэгтэйгээр МИРИМ консалт ХХК 2015 онд хийж дууссан. Судалгааны тайланг хянаж, ХААГ-ын саналыг тусгах ажил хийгдэж байна. Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолоор ХААГ-ын 2016 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны жагсаалтад Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, бүтээгдэхүүний төрөл тусгагдан батлагдсан. Ерөнхий гэрээ байгуулан худалдан авах бараа, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагаа 2016 оноос эхэлнэ.</p>			
--	--	--	--	--	--

4. Цахим тендер шалгаруулалтыг явуулж, олон нийтэд сурталчлан таниулна.

Худалдан авах ажиллагааны газар нь 2013 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53.7-д “Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нийт зарлах тендерийн 20-оос доошгүй хувийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулна” гэж заасны дагуу ХААГ-т зохион байгуулах нийт ажлын 22 хувийг цахим хэлбэрээр зохион байгуулсан. 2013 онд улсын хэмжээнд нийт 167 удаагийн тендерийг цахим хэлбэрээр зохион байгуулж, нийт 724 тендерийн саналыг хүлээн авсан нь дундажаар нэг тендэрт 4-5 оролцогч оролцсоныг илтгэж байна

ХААГ-аас 2014 онд өөрийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 100 хувь, орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүдийн зохион байгуулах худалдан авах ажиллагааны 20 хүртэлх хувийг цахим хэлбэрээр тус тус зохион байгуулах зорилт тавин ажилласан. Үүний дүнд, улсын хэмжээнд 475 удаагийн тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан

100%



Цахим худалдан авах ажиллагааны үзүүлэлтүүд, 2013-2015 он

тоогоор 1644 тендерийн саналыг хүлээн авсан бол 2015 онд 1212 удаагийн тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 4029 тендерийн саналыг хүлээн авсан нь цахим худалдан авах ажиллагааны системийн хэрэглээ 2,5-5,6 дахин ахисан үзүүлэлтийг харуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас төрийн худалдан авах ажиллагааны хүрээнд явуулж байгаа бодлогыг сурталчилах, худалдан авах ажиллагааг олон нийтэд мэдээлэх, Төрийн албан хаагчдад цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг танилцуулах, тэднийг чадавхижуулах

зорилгоор Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Сангийн яамтай хамтран “Шилэн Тендер” нээлттэй өдөрлөгийг 2012-2015 онд нийт 3 удаа, ил тод худалдан авалт нээлттэй өдөрлөгийг нийт 2 удаа тус тус

зохион байгуулж, тэдгээрт давхардсан тоогоор нийт 9000 орчим иргэд, олон нийт, хэрэглэгчдийн төлөөллийг хамруулсан дүнтэй байна.



Өдөрлөгт оролцогчдод ХААГ, орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгж, төрийн өмчийн оролцоотой ААН-үүдийн тухайн онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны

			<p>төлөвлөгөөг танилцуулахын зэрэгцээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах ажлыг олон нийтэд сурталчлан таниулж, тендерт оролцогч ААН, байгууллагуудыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт, бүтээн байгуулалтын гүйцэтгэлд хариуцлагатай, өндөр бүтээмжтэй оролцоход шаардлагатай мэдээлэл өгч, тэдний тендерт оролцох тэгш боломжийг бүрдүүлэн мэдээллийн ил тод байдлыг хангасан. Түүнчлэн төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөл, тэдний идэвх, оролцоог нэмэгдүүлсэн, уламжлалт ажил болж хэвшив.</p> <p>2012-2015 онд ХААГ-ын үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудас, олон нийтийн мэдээллийн сүлжээгээр давхардсан тоогоор 284 удаа мэдээлж, олон нийтийн хүртээл болгов.</p> <p>Тендерт оролцогч аж ахуй нэгж, байгууллагуудад зориулсан “Цахим худалдан авах ажиллагааны систем”-ийн сургалтыг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гаригт 10:00 цагаас үнэ төлбөргүй зохион байгуулж хэвшсэн бөгөөд 2013-2015 оны хугацаанд захиалагч болон тендерт оролцогч ААН-ийн нийт 4700 төлөөлөл хамрагдав.</p> <p>Орон нутгийн худалдан авах ажиллагааны 10 нэгжийн захиалгаар “Цахим худалдан авах ажиллагааны систем” www.meps.gov.mn – ийг ашиглан хэрхэн цахим тендер зохион байгуулах талаарх сургалтыг зохион байгуулсан байна.</p>			
--	--	--	--	--	--	--



			<p>Орон нутгийн худалдан авах ажиллагааны газар, албадын мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгч ажиллан, тендерт оролцогч аж ахуй нэгж, байгууллагуудад цахим системийн талаарх холбогдох мэдээлэл, заавар, зөвлөгөөг МТИХ-ээс болон байгууллагын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөс утсаар, уулзалтаар, цахим хэлбэрээр (TeamViewer) тус тус өгч ажилласан бөгөөд зөвхөн утсаар 11246 удаагийн 20975 минутын зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажилласан байна.</p> <p>Баян-Өлгий, Увс, Ховд, Архангай, Өмнөговь аймгуудад цахим худалдан авах ажиллагааны системийг таниулах, хэрхэн ашиглах талаар сургалт зохион байгуулж, захиалагч байгууллагын 49, ААН-ийн 184 төлөөллийг хамруулсан. Орон нутагт ийнхүү ажиллах явцад худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох шалгалтыг 219 хүнээс цахим хэлбэрээр авч, цахим шалгалтын тестчлэлийг амжилттай хийсэн.</p> <p>“Цахим худалдан авах ажиллагааны системийн II үе шат” төслийн хүрээнд 21 аймгийн худалдан ажиллагааны албадтай www.anymeeting.com системийг ашиглан уг төслийн танилцуулга, цахим хурал, цахим сургалтыг нийт 4 удаа зохион байгуулсан.</p>			
27	Төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх аж ахуйн нэгжид нийт борлуулалтын гучаас доошгүй хувийг өөрийн үйл ажиллагааны орлогоос олдог байх шаардлага тавих;	1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, үүнтэй уялдуулан тендерийн бичиг баримт, үнэлгээний зааварт холбогдох өөрчлөлтийг оруулан, төсвийн ерөнхийлөн захирагч нараар мөрдүүлж ажиллана.	<p>Худалдан авах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, ойлголтын зөрүүг арилгах зорилгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2013-2015 онд ХААГ-аас 2 удаа боловсруулан Сангийн яам, үе үеийн Шадар сайдын Ажлын албанд хүргүүлсэн.</p> <p>Тухайлбал, тайлант жилд Засгийн газрын хуралдааны 2015 оны 01 сарын 09-ний өдрийн 04 дүгээр тэмдэглэлээр “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хянан боловсруулж, 2015 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд оруулах тухай” үүргийг Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайдад тус тус даалгасны дагуу ХААГ-аас хуулийн шинэчилсэн төслийг боловсруулж, тухайн үеийн Шадар сайдын Ажлын албанд хүргүүлсэн. Уг төсөлд байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтээс болон хэрэглэгчдээс</p>	90%		

			<p>санал авч тусгасан.</p> <p>Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 08 сарын 03-ны өдрийн 94 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг бүрэлдэхүүнд ШСАА-ны Ахлах зөвлөх, Сангийн яам, тус байгууллагын холбогдох төлөөлөл оролцсон бөгөөд уг Ажлын хэсэг ШСАА-нд нэг удаа хуралдаж, хуулийн төслийн асуудлаар санал солилцсон. Олон улсын судалгааны баг ажиллаж холбогдох судалгаа хийсний дараа хуулийн төслийг боловсруулах асуудлыг 2016 оны 5 сар хүртэл хойшлуулахаар төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас шийдвэрлэсэн.</p> <p>ХААГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу улсын болон бүс нутгийн чанартай томоохон төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд тендерийн баримт бичгийн шаардлагад тендерт оролцогч ААН-ийн сүүлийн 3 жилийн дундаж борлуулалтын орлого тендерт санал болгож буй үнийн саналын 30-50 хувиас багагүй байхаар тооцож тогтмол тусгаж хэвшсэн.</p> <p>АҮЯ, ШӨХТГ-тай хамтарсан уулзалтыг 2016.02.02-ны өдөр зохион байгуулсан бөгөөд АҮЯ-ны 12, ШӨХТГ-ын 2, ХААГ-ын дарга, хэлтсийн дарга нар, мэргэжилтнүүд, нийт 30 хүн оролцож, дотоодод үйлдвэрлэсэн чанар, стандартын шаардлага хангасан барааг тендерийн баримт бичигт хэрхэн тусгах талаар ярилцаж, уг асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий СЯ, АҮЯ, ХААГ-ын төлөөллийг оролцуулан ажлын хэсгийг байгуулж, журам боловсруулахаар шийдвэрлэв. Уг уулзалтаар хэлэлцсэн асуудлын хүрээнд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10¹.1 дүгээр зүйлийг ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтанд хэрхэн хэрэглэх талаар чиглэл хүсч, Сангийн яаманд 2016.02.04-ний өдрийн 1/87 дугаар албан бичгийг боловсруулан, хүргүүлээд байна.</p>			
--	--	--	---	--	--	--

- ✓ Худалдан авах ажиллагаатай хамааралтай нийт 2 зорилтын хүрээнд Сангийн яамтай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан 5 арга хэмжээг бүртгэл хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Эдгээр 5 хэрэгжүүлэх арга хэмжээнээс 2 (17.1 ба 17.2 дахь) арга хэмжээг тус агентлагийн үйл ажиллагаанд хамааруулан хэрэгжүүлэх боломжгүй байх тул хэрэгжилтийн хувийг тооцоогүй. Шалтгааныг тухайн заалтад харгалзах “Хэрэгжилтийн тухай тэмдэглэл” хэсэгт тэмдэглэсэн болно.
- ✓ Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-д заасан аргачлалын дагуу хэрэгжилтийг тооцов.
- ✓ Тус байгууллагын үйл ажиллагаанд хамаарч, байгаа нийт **3 заалтын** хэрэгжилт 2015 оны жилийн эцсийн өссөн дүнгээр:
 - **100 хувьтай хэрэгжүүлсэн заалт 1,**
 - **90 хувьтай хэрэгжиж байгаа заалт 1,**
 - **70 хувьтай хэрэгжиж байгаа заалт 1 тус тус байна.**
 - ХААГ-ын Сангийн яамтай хамтран хэрэгжүүлж байгаа эдгээр 3 арга хэмжээний хэрэгжилт дунджаар **86,7 хувийн гүйцэтгэлтэйгээр** дүгнэгдэв.

ХЯНАСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ЖАРГАЛАН

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ